

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРЭЭР ДАМЖИН ӨНГӨРӨХ БОЛОН ТҮР
ХУГАЦААГААР ОРЖ ИРЖ БАЙГАА АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ЭЗЭМШИГЧ, ӨМЧЛӨГЧИЙГ ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН
АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛД ХАМРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар нэвтэрч байгаа /цаашид “Улсын хилээр нэвтэрч байгаа” гэх/ авто тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг даатгалд хамруулах, Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Монгол Улс гишүүнээр нь элсэн орсон олон улсын албан журмын даатгалын холбооны гишүүн орны даатгалын эрх бүхий байгууллагад даатгуулсан этгээд нь Жолоочийн даатгалын тухай хуулиар тогтоосон даатгалд хамрагдахгүй байж болно.

Хоёр. Хилийн бүсэд даатгалын үйл ажиллагаа явуулах

2.1. Улсын хилээр нэвтэрч байгаа авто тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах үйл ажиллагааг хилийн бүсэд зохион байгуулна.

2.2. Даатгалын зуучлагч компани нь хилийн бүсэд үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Хилийн тухай хуульд ~~26 дугаар зүйлийн 2.4-г~~ заасны дагуу улсын хил хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авна.

2.3. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн бүсэд мөрдөх журмыг хэрэгжүүлэхийн тулд авто тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг ~~Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх, түр хугацаагаар улсын хилээр нэвтрэж~~ улсын хилээр нэвтэрч байгаа тухайн боомтын чиглэлд даатгалд хамруулах үйл ажиллагааг даатгалын зуучлагч ~~нэг компани~~ явуулна.

2.4. Даатгагч, даатгуулагчийн ашиг сонирхлыг төлөөлөн хилийн бүсэд ажиллах даатгалын зуучлагчийг ~~компанийг~~ Санхүүгийн зохицуулах хороо, улсын хил хамгаалах ~~ерөнхий газраас~~ байгууллагаас зарласан нээлттэй сонгон шалгаруулалтад үндэслэн сонгож, хилийн бүсэд даатгал хийх зөвшөөрөл олгоно.

2.5. ~~Улсын хил хамгаалах ерөнхий газар байгууллага нь~~ Нээлттэй сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хороо, Улсын хил хамгаалах байгууллагатай харилцан ~~зөвшилцөнө~~ зөвшилцөж тогтооно.

2.6. Хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй даатгалын зуучлагч ~~компани~~ нь хилийн бүсэд мөрдөх журмыг хэрэгжүүлэх, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын болон олон улсын гэрээ, хилийн тухай бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой улсын хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан хаагчийн ~~жилчдийн~~ тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Жич: *Журамд оруулах өөрчлөлтийг төсөлд тусгахдаа хасагдсаныг дундуур зураасаар, нэмэгдсэнийг доогуур зураасаар тэмдэглэсэн болно.*

Гурав. Албан журмын даатгалд хамрагдах

3.1 ~~Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар нэвтэрч байгаа~~ Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу Улсын хилээр нэвтэрч байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгч нь ~~Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу~~ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн өмнө хүлээх хариуцлагаа жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулна.

3.2 Монгол Улсад ~~нутаг дэвсгэр дээр~~ байнга оршин суудаггүй гадаадын иргэн, харьяалалгүй этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа болон Монгол Улсын авто тээврийн хэрэгслийн дугаар түр авсан авто тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийг жөлөөчийн хариуцлагыг энэхүү журмын дагуу албан журмын даатгалд хамруулна.

3.3 ~~Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа~~ Улсын хилээр нэвтэрч байгаа авто тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгч нь энэ журмын 1.2, ~~1.3~~ дугаар зүйлүүдэд заасан гэрээ хэлэлцээрийн хүрээнд жолоочийн албан журмын даатгалаас чөлөөлөгдөж болно.

Дөрөв. Даатгалын гэрээний хугацаа, нөхөн төлбөр

4.1. Даатгалын гэрээг тухайн авто тээврийн хэрэгслийг Монгол Улсын нутаг дэвсгэрт эзэмших, ашиглах хугацаагаар байгуулна.

4.2. Байнгын ачаа эсхүл зорчигч тээвэрлэлт хийдэг, ~~Монгол Улсын~~ хилээр нэвтэрч буй авто тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг даатгалд хамруулахдаа Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон улс хооронд тээвэр хийх зөвшөөрлийн хугацааг харгалзан, тухайн хугацаанд даатгалын гэрээ байгуулна.

4.3. Даатгалын нөхөн төлбөрийг дараах байдлаар тооцож олгоно:

4.3.1. Жолоочийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолтыг ~~Жөлөөчийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасныг~~ үндэслэнэ;

4.3.2. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасны дагуу зам тээврийн осолд орсон хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон эсэхээс үл хамааран даатгагч, жолоочийн даатгалын сан нь ~~Жөлөөчийн даатгалын тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан журмын дагуу~~ даатгалын хохирлын хэмжээг тогтоосноос хойш ажлын 10 хоногийн дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгох;

4.3.3. ~~Даатгалын нөхөн төлбөртэй холбоотой бусад асуудлыг Жөлөөчийн даатгалын тухай хууль, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний дагуу зохицуулна.~~

Тав. Хяналт, хариуцлага

5.1. Энэ журмаар зохицуулаагүй жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой харилцааг Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

Жич: *Журамд оруулах өөрчлөлтийг төсөлд тусгахдаа хасагдсаныг дундуур зураасаар, нэмэгдсэнийг доогуур зураасаар тэмдэглэсэн болно.*

5.2. Санхүүгийн зохицуулах хороо болон Улсын хил хамгаалах ерөнхий газар байгууллага нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, журам зөрчигдсөн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Шилжилтийн заалт-Бусад

6.1. ОХУ, БНХАУ болон бусад улсын Засгийн газартай байгуулсан Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын болон Авто тээврийн хэлэлцээрт өөрөөр заасан бол уг хэлэлцээрийг баримтална.

6.2. Энэ журмын 6.1-д заасан хэлэлцээр шинээр батлагдсан тохиолдолд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг уг хэлэлцээрт нийцүүлэн даатгагч, даатгуулагч шинээр байгуулах үүрэгтэй.

-----ooOoo-----

Жич: *Журамд оруулах өөрчлөлтийг төсөлд тусгахдаа хасагдсаныг дундуур зураасаар, нэмэгдсэнийг доогуур зураасаар тэмдэглэсэн болно.*